



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/704

Арвайхээр


**Газар ашиглалтын зориулалтад  
өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3.4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу 13 дугаар баг Залуучуудын 3 дугаар гудамж 302 тоотод байрлах Б.Жанчивдоржийн эзэмшил нийтийн орон сууцны зориулалттай 600м<sup>2</sup> газар, 302а тоотод байрлах С.Чимэддуламын эзэмшил 600м<sup>2</sup> газрын зориулалтыг амины орон сууцны зориулалттай болгон тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101541

D:My Doc. Zahiramj. Zasag darga